



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

1084 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 9/344

Улаанбаатар хот


Г Улаанбурхан өвчний
дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.13, 8.1.21 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 261 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нөхөн дархлаажуулалтын журам”-ын гурав дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, улаанбурханы эсрэг дархлаажуулалтын зааварчилгаа хүснэгтийг хоёрдугаар, дархлаажуулалтыг зохион байгуулах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэгдүгээр хавсралтаар баталсан удирдамжийн дагуу улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т даалгасугай.



171241489

08 Эрүүл мэндийн сайдын 2024 оны
..... дугаар сарын 09 өдрийн 10 дугаар
тушаалтын нэгдүгээр хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

1. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед халдвараас сэргийлэх, тархалтыг хязгаарлах, өвчлөл, хүндрэл, нас баралтаас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтыг зохион байгуулна.
2. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед зорилтот бүлгийг улаанбурханы эсрэг дархлаажуулалтад нэн тэргүүнд дараах байдлаар хамруулна.
 - 2.1. Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд
 - 2.1.1. Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан болон өвдөж байсан эсэх нь тодорхойгүй, улаанбурхан, улаануудын эсрэг вакцинд (ҮҮ) хамрагдсанаас хойш 5 ба түүнээс дээш жил болсон эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнуудыг 1 тунгаар дархлаажуулна.
 - 2.1.2. Улаанбурхан өвчний эсрэг товтолын болон нэмэлт дархлаажуулалтад хамрагдаагүй болон улаанбурхан өвчнөөр өвдөж байгаагүй нь тодорхой эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнуудыг ҮҮ вакцины 1 тунгаар дархлаажуулж, 2 дахь тунг нэг сарын зйтай хийнэ.
 - 2.1.3. Эрүүл мэндийн байгууллагууд харьяа аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвөөс шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийг татан авна.
 - 2.2. Батлагдсан тохиолдлын хавьтлыг 72 цагийн дотор дараах байдлаар дархлаажуулна.
 - 2.2.1. Улаанбурхан өвчинеэр өвдсөн эсэх болон улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан эсэхээ мэдэхгүй, улаанбурхан өвчний эсрэг вакцины (ҮҮ эсвэл ҮГҮ) 1-р тунд хамрагдсан 16 ба түүнээс дээш насын хүн бол ҮҮ вакцины 1 тунгаар дархлаажуулна.
 - 2.2.2. Улаанбурхан өвчинеэр өвдөж байгаагүй болон улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдаагүй нь тодорхой 16 ба түүнээс дээш насын хүнийг ҮҮ вакцины 1 тунгаар дархлаажуулж, 2 дахь тунг нэг сарын зйтай хийнэ.
 - 2.2.3. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг (ҮГҮ) вакцины 2-р тунд хамрагдаагүй 16 хүртэлх насын хүүхэд бол Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаалтын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нөхөн дархлаажуулалт хийх журам”-ын дагуу дархлаажуулна.
 - 2.2.4. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг (ҮГҮ) вакцины 1, 2-р тунд хамрагдаагүй, улаанбурхан өвчинеэр өвдөж байгаагүй 16 хүртэлх насын хүүхэд бол Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаалтын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нөхөн дархлаажуулалт хийх журам”-ын дагуу дархлаажуулна.
 - 2.2.5. Вакцины зааврын дагуу дархлаажуулалтын эсрэг заалттай хүн, жирэмсэн эмэгтэй, 6 хүртэлх сартай хүүхдэд улаанбурханы эсрэг вакцин хийхгүй.

2.2.6. Энэхүү удирдамжийн 2.2.5.-д дурдсан хүнийг батлагдсан тохиолдолтой хавьтал болсноос хойш 6 хоногийн дотор иммуноглобулиноор зааврын дагуу урьдчилан сэргийлэлт хийнэ.

2.3. Товлолын дархлаажуулалтад хамрагдаагүй 18 хүртэлх насын хүүхэд

2.3.1. Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг (ҮГҮ) вакцины 1-р тунд хамрагдсан боловч 2-р тунд хамрагдаагүй 16 хүртэлх настай хүүхдийг Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нөхөн дархлаажуулалт хийх журам”-ын дагуу нөхөн дархлаажуулна.

2.3.2. Товлолын дагуу улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдаагүй, улаанбурхан өвчинеөр өвдөж байгаагүй нь тодорхой 16 хүртэлх насын хүүхэд бол Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нөхөн дархлаажуулалт хийх журам”-ын дагуу нөхөн дархлаажуулна.

2.3.3. Товлолын дагуу улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдаагүй, улаанбурхан өвчинеөр өвдөж байгаагүй нь тодорхой 16-18 насын хүүхэд бол ҮҮ вакцины 1 тунгаар дархлаажуулж, 2 дахь тунг нэг сарын зйтай хийнэ.

2.3.4. Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан эсэх болон өвдөж байсан эсэх нь тодорхойгүй 16-18 насын хүүхэд бол ҮҮ вакцины 1 тунгаар дархлаажуулна.

2.4. 2023 онд зохион байгуулсан улаанбурханы эсрэг нэмэлт дархлаажуулалтаас хоцорсон 3-9 настай хүүхэд

2.4.1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны A/188 дугаар тушаалаар зохион байгуулсан улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтаас хоцорсон 3-9 настай хүүхдийг халдвартын нөхцөл байдлаас шалтгаалан эцэг эхийн хүсэлтээр ҮҮ вакцинаар нөхөн нэмэлт дархлаажуулж болно.

3. Дархлаажуулалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэлтийг дараах байдлаар хийнэ.

- 3.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дархлаажуулалтын хамралт, вакцины нөөцийн мэдээг 17 цагаар тасалбар болгож, 18 цагаас өмнө өдөр бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанад мэдээлнэ.
- 3.2. Вакцинатор дархлаажуулалтын цахим бүртгэлд зөвхөн өөрийн эрхээр нэвтрэх ба мэдээллийн санд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- 3.3. Дархлаажуулалтын мэдээллийн санд мэдээлэл нөхөн оруулахдаа тухайн хүүхдэд улаанбурханы эсрэг вакцин хийсэн тэмдэглэгээ бүхий дархлаажуулалтын анхан шатны бүртгэлийн маяттууд (ЭМС-ын 2019 оны A/611 дүгээр) дээрх мэдээлэлд зөвхөн үндэслэн бүртгэнэ.
- 3.4. Мэдээллийн сангийн үнэн зөв байдалд аймаг, нийслэлийн ЭМГ, дүүргийн ЭМТ-ийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтнүүд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

- 3.5. Заавал хийх товлолын дагуу дархлаажуулалтад хамрагдсан 2006-2018 онд төрсөн хүүхдүүдийн мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://health.gov.mn/>)-д бүрэн бүртгэнэ.
- 3.6. Улаанбурханы эсрэг вакцинд хамрагдаагүй 16-18 насны хүүхэд бол улаанбурхан, улаанууд (ҮҮ)-ын эсрэг вакцинаар дархлаажуулж дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn>)-д бүртгэнэ.
- 3.7. 2023 онд зохион байгуулсан улаанбурханы эсрэг нэмэлт дархлаажуулалтаас хоцорсон 3-9 настай хүүхдийг улаанбурхан, улаануудын эсрэг (ҮҮ) вакцинаар дархлаажуулсан бол дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn>)-д бүртгэнэ.
- 3.8. Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнуудыг улаанбурханы эсрэг вакцинд хамруулсан мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn>)-д бүртгэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
08 дугаар сарын 08 өдрийн 11 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

УЛААНБУРХАНЫ ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ЗААВАРЧИЛГАА ХҮСНЭГТ

НАС	ТОВЛОЛ		НЭМЭЛТ	2024		
	ҮГҮ I	ҮГҮ II		ҮГҮ I	ҮГҮ II	ҮҮ
9 сар – 2 нас	Заавал хийх үндэсний товтолыг баримтлан дархлаажуулна.					
3-6 нас	+	+	+			
	+	+	-			Тийм
	+	-	-		ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
	-	-	-	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
	-	-	+	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
	Тодорхойгүй			ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
7-9 нас	+	+	+			
	+	+	-			Тийм
	+	-	-		ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
	-	-	-	ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна		
	Тодорхойгүй			ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна		
10-15 нас	+	+				
	+	-			ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна	
	-	-		ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна		
	Тодорхойгүй			ЭМС-ын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу нөхөн дархлаажуулна		
16-18 нас	+	+				
	+	-				Тийм
	-	-				Тийм (I; II)
	Тодорхойгүй					Тийм (I; II)

- (+) Вакцин хийлгэсэн
(-) Вакцин хийлгээгүй
Вакцин хийнэ.

Эрүүл мэ нийн сайдын 2024 оны
дугаар сарын 01-р өдрийн дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ДАРХЛАЖКУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
Нэг. Зохион байгуулалт, бүртгэл, судалгаа				
1.2	Улаанбурхан Өвчиний дэгдэлтийн чийн дархлаажкуулалтыг зохион байгуулах сургалтыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнуудийг хамруулан зохион байгуулах	2024 оны 08 дугаар сарын 06-09 өдөр	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
1.3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт вакцинжуулагдсан хүүхдийг бүртгэж, хамруулах ажлын хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвөөс дархлаажкуулалтад хамрагдаагүй 18 хүртэлх насны хүүхдийн вакцинжуулалтын бүртгэлийг гаргаж, төвлөлийн дархлаажкуулалтад хамрагдаагүй хүүхдийг нөхөн дархлаажуулах, цахимд бүртгэл мэдээлэл оруулахад хяналт тавих	2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор	ЭМЯ, ХӨСҮТ	Бүх түвшний засаг дарга, Аймаг, нийслэлийн ЭМГ
1.4	Зорилтот булагийн эрэмбэлэлтийн дагуу эрүүл мэндийн байгууллагын ажилтан, хилийн нэвтрэн цэгийн ажилтнуудыг дархлаажуулах	2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор	ЭМЯ, ХӨСҮТ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
1.5	Нэмэлтээр шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийн тооцоолоп, захиалгыг хийж, хангандийлүүлэлтийг шуурхай зохион байгуулах	2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор	ЭМЯ, ХӨСҮТ	НҮБ-ийн Хүүхдийн сан
1.8	Дархлаажкуулалтын хамралт, дархлаажкуулалтын мэдээг дараа гарч болох урвал хүндэрэлийн	2024 оны 08 дугаар сарын 10-	Аймаг	ХӨСҮТ
			нийслэлийн ЭМГ	

	Дархлаажуулалтын нэгжээс өдөр бур авах (хамрагдсан зорилтот бүлгийн хүн амьн нэгдсэн бүртгэлийг дэлгэрэнгүй авах, мэдээллийн сан бүрдүүлэх)	ны өдрийн дотор		
1.9	Улаанбурхан, улаануудын эсрэг вакциныг батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлд тасралтуй түгээх	2024 онд	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
1.10	Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан дархлаажуулах	2024 оны 09 дугээр сард	ХӨСҮТ	Аймаг, сүм, засаг аймаг, дүүргийн хорооны идэвхтэн
1.11	Асрамж, халамжийн газар болон хүүхэд тур хамгаалах байрны хүүхдүүдийн улаанбурханы товтолын вакцин болон нөхөн вакцинд хамрагдсан эсэх судалгааг гарган, улаанбурханы эсрэг вакцинаар дархлаажуулах	2024 оны 08-09 дугээр сар	ЭМЯ, ХӨСҮТ	ГБХНХЯ, ХҮҮХЭД, гэр булийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
1.12	Халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 6-8 сартай хүүхдүүдийг улаанбурханы эсрэг вакцинаар дархлаажуулах	2024 онд	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
Хоёр. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсэн үнэлгээ				
2.1	Дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх	2024 оны 08-09 дугээр сар	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
2.2	Хамралтын түргэвчилсэн үнэлгээ шийдвэрлэхэд тохиолдолд дархлаажуулах	2024 оны 08-09 дугээр сар	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
2.3	Дархлаажуулалтын үйл ажиллагаа, хамралтын өдөр тутмын болон явцын мэдээг гаргах, нэгдсэн тайлланг шийдвэр гаргачдад хургуулэх	2024 оны 08-09 дугээр сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ